



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2005 оны 3 сарын 31 өдөр

Дугаар 117

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 28 дугаар зүйлийн 1.3 дугаар заалт, Засгийн газрын 2005 оны 15 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2005 оны 22 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Улаанбаатар хотын Захирагчийн харьяа "Ус сувгийн удирдах газар"-ын дүрмийг хавсралтаар баталсугай.

Хоёр. "Ус сувгийн удирдах газар"-ын бүтэц, орон тоо, дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захирагчийн ажлын алба /Г.Мөнхбаяр/-нд үүрэг болгосугай.

Гурав. Энэ захирамж гарсантай холбогдуулан нийслэлийн Засаг даргын 2001 оны 35 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

(Handwritten signature)
М.ЭНХБОЛД



Нийслэлийн Засаг даргын 2005 оны 3 дугаар сарын 31 ний өдрийн 117 дугаар захирамжийн хавсралт

“УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР” (НӨҮГ)-ЫН ДҮРЭМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Улаанбаатар хотын Захирагчийн харъяа Ус сувгийн удирдах газар нь (цаашид газар гэх) Нийслэлийн өмчид үндэслэн байгуулагдсан улсын үйлдвэрийн газар буюу хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулна.

1.2. Газрын үйл ажиллагаанд Монгол улсын Үндсэн хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нөхөрлөл, компаний тухай хууль бусад холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, мөрийн хөтөлбөр, энэхүү дүрмийг удирдлага болгоно.

1.3. Газрын зорилго нь Улаанбаатар хотын хэрэглэгчдийг унд, ахуйн стандартад тохирсон усаар тасралтгүй хангаж, экологийн тэнцвэрийг хадгалах шалгуурт тохирох усыг байгальд нийлүүлнэ.

1.4. Газар нь оорт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээд мөн.

1.5. Газар нь тогтоосон журмын дагуу хийгдсэн тэмдэг, бэлэгдэл, албан бичгийн хэвлэмэл хуудас, банкинд харилцах данстай байна.

1.6. Газар нь Нийслэлийн Баянзүрх дүүргийн 3-р хороо Токиогийн гудамжинд байрлана. Утас: (976-11)-455055, факс: (976-11)-450120

Хоёр. Удирдлага зохион байгуулалт, үүсгэн байгуулагчийн эрх

2.1. Газрын даргыг Удирдах зөвлөлийн саналыг үндэслэн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч томилж, чөлөөлнө.

2.2. Газрын дэд даргыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай зөвшилцсөний үндсэн дээр Газрын дарга томилж, чөлөөлнө.

2.3. Газар нь үйл ажиллагаагаа Улаанбаатар хотын Захирагч, түүний Ажлын албаны Удирдах зөвлөлийн удирдлага дор явуулж ажлаа тайлагнана.

2.4. Газрын дүрмийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч баталж, бүтэц, орон тооны хязгаарт Ерөнхий менежер хяналт тавина.

2.5.Газрын дарга нь байгууллагын бүтэц, дотоод журам, орон тоо, цалингийн хэмжээ, урамшууллын журмыг тогтоож мөрдүүлэх ба албан хаагчдыг томилж, чөлөөлнө.

2.6.Газрын дарга нь эрх хэмжээнийхээ хүрээнд Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргаж, байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод ашиглаж эзэмшинэ.

2.7.Газрын Удирдах зөвлөлийн дарга, гишүүдийг 4 жилийн хугацаагаар Нийслэлийн Засаг даргын захирамжаар томилно.

2.8.Удирдах зөвлөлийн дарга, гишүүд хууль бус үйл ажиллагаа явуулах, баримт бичиг хуурамчаар үйлдэх, ажилд хайнга хандвал тэднийг хэдийд ч өөрчилж болно.

2.9.Газрын даргын эрх, үүрэг, хариуцлага, цалин хөлс, урамшуулал болон бусад харилцааг Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын Захиралтай байгуулах гэрээгээр зохицуулах бөгөөд энэхүү гэрээг Өмчийн харилцааны газар, үйл ажиллагааны чиглэлээр Ерөнхий менежертэй гэрээ байгуулан ажиллана.

Гурав. Газрын үйл ажиллагааны эрх хэмжээ

3.1. Газрыг байгуулах тухай шийдвэр гарсан өдрөөс байгуулагдсанд тооцож компаний тухай хуулинд заасан журмаар бүртгүүлж хуулийн этгээдийн эрхтэй болно.

3.2.Газар нь өөрийн нэрийн өмнөөс гадаад, дотоодын байгууллагатай эрх зүйн харилцаанд орох, эд хөрөнгө болон эд хөрөнгийн бус эрх эдлэх, үүрэг хүлээх түүнчлэн шүүх, арбитрийн байгуулагад нэхэмжлэгч буюу хариуцагчаар оролцоно.

3.3.Газар нь үйлчилгээний үнийн саналаа Нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан үнийн комисст оруулан зөвшилцөж шийдвэрлэнэ.

3.4.Ашиглалт, засварын ажилд шаардагдах түүхий эд, материал, тоног төхөөрөмжийг гадаад, дотоодын зах зээлээс бие даан бэлтгэнэ.

3.6.Газар нь дараах хөрөнгийн эрх үүрэгтэй

а) Өөрийн эд хөрөнгийн бүрэн байдлыг хангаж үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмшиж ашиглана;

б) Үндсэн хөрөнгийг холбогдох хууль тогтоомжинд заасан эрх хэмжээнийхээ дотор захиран зарцуулна;

в) Төвлөрсөн болон Нийслэлийн төсвөөс олгосон хөрөнгийг төсвийн хууль, зардлын зориулалтын дагуу зарцуулж тайлагнана.

г) Ажил үйлчилгээ үзүүлсний үр дүнд олсон ашгийг эрх бүхий байгууллагаас тогтоосон нормативт хэмжээгээр үлдээж хууль, тогтоомжийн дагуу захиран зарцуулна;

д) Үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, төрийн өмчийн бус этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах, шилжүүлэх болон худалдах, хувьчлахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулинд заасан журмыг баримтлана.

3.7. Газар нь дор дурдсан үйл ажиллагааг явуулна

а) Нийслэлийн хүн ам, байгууллага, аж ахуйн нэгжийн усны хэрэгцээг унд-ахуйн стандартын шаардлагад тохирсон цэвэр усаар байнга тасралтгүй хангана;

б) Нийслэлийн алслагдсан дүүргүүд болох Багахангай, Багануур, Налайхын ус сувгийн байгууллагуудын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангана;

в) Бохирдсон усыг зохих стандартын дагуу цэвэрлэж зайлуулна;

г) Хэрэглэгчдийн усны алдагдлыг бууруулах, усны бохирдолтын хэмжээнд хяналт тавина;

д) Усны эх үүсвэр, нөөцийг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлнэ;

е) Цэвэр бохир усанд стандартын дагуу лабораторийн шинжилгээ хийж өдөр тутмын хяналт тавина;

ж) Усны тоолуур баталгаажуулах, угсрах үйл ажиллагаа явуулна.

Дөрөв. Газрын удирдах зөвлөл, түүний эрх хэмжээ

4.1. Газар нь Удирдах зөвлөлтэй байж болно.

4.2. Удирдах зөвлөл 5-аас доошгүй гишүүнтэй байна.

4.3. Удирдах зөвлөл нь газрын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтооно.

4.4. Газрын Стратегийн дунд хугацааны төлөвлөгөө батлуулахаар Засаг даргад өргөн барина.

4.5. Зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журмыг батлана.

4.6. Зөвлөл нь Газрын салбар нэгж байгуулан ажиллаж болно.

4.7. Газрын зохион байгуулалтын бүтэц, ажиллагсдын цалин, орлого, зардлын хэмжээ, урамшууллын журмыг тогтооно.

4.8. Газрын өмч хөрөнгийг захиран зарцуулах талаар даргын эрх хэмжээг тогтоож өгнө.

4.9. Дарга болон газрын үйл ажиллагаанд дотоодын хяналт тавина.

4.10. Удирдах зөвлөл нь жилд 1-ээс доошгүй удаа НИТХ-д ажлаа тайлагнана.

4.11. Дараах асуудлаар өмчлөгчид санал өгч байна.

а) Газрын дүрэмд өөрчлөлт, нэмэлт оруулах санал оруулна;

б) Газрын үйл ажиллагаа, санхүүгийн байдалд тодорхой нөлөө үзүүлэхүйц хамтын ажиллагааны хэлэлцээр, гэрээг хянана;

в) Цэвэр, бохир усны тарифын түвшинд судалгаа хийж өөрчлөлт оруулах санал боловсруулах.

4.12. Удирдах зөвлөлийн хурал улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Гишүүдийн дийлэнх олонхи оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.

4.13. Удирдах зөвлөлийн дарга, гишүүд ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.

4.14. Зөвлөлийн хуралд оролцогчдын дийлэнх олонхоор шийдвэр хүчин тогтолдөр болно. Удирдах зөвлөлийн хурлаас тогтоол гаргах бөгөөд түүнд зөвлөлийн дарга гарын үсэг зурж Газрын тэмдэг дарна.

4.15. Удирдах зөвлөлийн ажиглах журмыг Удирдах зөвлөл Нийслэлийн Засаг даргатай зөвшилцөж тогтооно.

4.16. Газрын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн норм, ажиллагсдын орон тооны норматив, материал зарцуулалтын норм тогтооно.

4.17. Хуульд заасан бусад бүрэн эрхийг эдэлнэ.

Тав. Газрын удирдлага, түүний эрх үүрэг

5.1. Дарга нь дүрэм болон гэрээнд заасан хугацаанд тогтоож өгсөн эрх хэмжээний дотор Газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.

5.2. Газрын дарга Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, Захирагчийн ажлын албаны дарга ерөнхий менежер, УСУГазрын Удирдах зөвлөлийн өмнө ажлаа тайлагнана.

5.3. Удирдах зөвлөлийн хурал хуралдуулах тухай саналыг түүний дарга буюу гишүүдэд Газрын дарга гаргаж болно.

5.4. Газрын дарга нь үйл ажиллагаатай холбоотой гэрээ хэлэлцээрийг Удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний дотор хийнэ.

5.5. Газрын даргатай холбогдон үүссэн маргааныг шүүх хянан шийдвэрлэхэд Удирдах зөвлөлөөс томилсон Удирдах зөвлөлийн гишүүн Газрыг төлөөлөн оролцоно.

5.6. Газрын даргын эдлэх эрх, хүлээх хариуцлага, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэрэг асуудлыг гэрээнд тусгана.

5.7. Дарга дараах эрх, үүрэгтэй

- а) Газрын дарга нь ажилтныг холбогдох хууль тогтоомжийн дагуу ажилд авах, чөлөөлөх, сахилгын арга хэмжээ авах, тэдний цалинг тогтооно;
- б) Газрыг гадаад, дотоодод итгэмжлэлгүйгээр төлөөлөх, итгэмжлэл олгоно;
- в) Газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулна;
- г) Газрын жил бүрийн бизнес төлөвлөгөө боловсруулж Удирдах зөвлөлөөр батлуулан биелэлтийг хангана;
- д) Газрын үйлдвэрлэл, технологийн нууцад хамаарах мэдээллийг тогтооно;
- е) Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцсэн газрын хөдөлмөрийн дотоод журам баталж мөрдүүлнэ;
- ж) Тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж тэдгээрийн үнэн зөвийг хариуцна;
- з) Маргаантай асуудлаар газраа төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана;
- и) Эрх хэмжээнийхээ хүрээнд Газрын хэмжээнд дагаж мөрдөх тушаал, зааварыг холбогдох хууль тогтоомжоор нийцүүлэн гаргана;
- к) Удирдах зөвлөлөөс даргад эрхэлсэн ажлын чиглэлээр тусгайлан даалгасан үүргийг хэрэгжүүлнэ;
- л) Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүргийг эдэлнэ.

5.8. Дарга нь хувийн эрх ашгийн үүднээс Газрын нэрийг ашиглан гэрээ хэлцэл хийхийг хориглоно.

Зургаа. Эд хөрөнгө, санхүүгийн бүртгэл, хяналт

6.1. Газрын эд хөрөнгө, санхүүгийн бүртгэл, тайланг Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу явуулна.

6.2. Газрын санхүүгийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 1 нээс эхэлж, 12 дугаар сарын 31 ний өдөр дуусна. Санхүүгийн анхны жил нь газар байгуулагдсан өдрөөс эхэлж хуанлийн жилийн 12 дугаар сарын 31 ний өдөр дуусах ба санхүүгийн сүүлчийн жил нь газрыг татан буулгасан өдрөөр дууссанд тооцно.

6.3. Газар нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу орлогын болон бусад татвар хураамжийг төлнө.

6.4. Газар нь анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтлөн, тайлан тэнцлийг улирлаар гаргаж, Татварын алба, санхүүгийн байгууллагад тушаана.

6.5. Газар нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэлийг тооцно.

6.6. Газрын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг хууль тогтоомжид заасан байгууллага хэрэгжүүлнэ.

6.7. Газрын удирдлага нь газрын үйл ажиллагаанд шалгалт хийхэд шаардагдах бүх баримт материалаар хангана.

6.8. Газрын тооцоо, тайлангийн мөнгөн дүнг төгрөгөөр илэрхийлнэ. Бэлэн мөнгө болон банкинд хадгалагдаж буй мөнгөн хөрөнгө түүнчлэн орлого, зарлага, төлөгдөөгүй өр зэрэг нь анх оруулсан валютын хэлбэрээр байна. Нягтлан бодох бүртгэлийн бичилт хийх зорилгоор төгрөгт хөрвүүлэхэд Монгол банкны тухайн үеийн албан ёсны ханшаар тооцно.

6.9. Үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, төрийн өмчийн бус этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах болон худалдах, хувьчлахдаа төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулинд заасан журмыг баримтлана.

Долоо. Байгуулах, бүртгэх, өөрчлөх, татан буулгах

7.1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн санал болгосноор Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Газрыг үүсгэн байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг шийдвэрлэнэ.

7.2. УСУГазрын татан буулгах тохиолдолд НИТХ-аас томилсон комисс уг ажлыг эрхэлнэ.

7.3. Татан буулгах комисс нь дуусгалтын тайлан тэнцэл гаргуулан, НИТХ-д танилцуулж, нийтэд мэдэрлж, өр төлбөрийг хуульд заасан дараалал, журмын дагуу төлсөний дараа үлдсэн хөрөнгийг 3 сарын дотор Нийслэлийн өмчийн харилцааны газарт шилжүүлнэ.

Найм. Хариуцлага

8.1. Газрын албан тушаалтан нь байгууллагын дүрэм, дотоод журамд заасан үүргийг биелүүлж, байгууллагын ашиг сонирхлын төлөө шударгаар ажиллана.

8.2. Монгол улсын хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн захирамж, шийдвэрийн биелэлтийг хэрэгжүүлэх явцад буруу шийдвэр гаргаж, бусдад хохирол учруулсан нь шүүхээр тогтоогдсон бол холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

8.3. Газрын дарга нь эрх мэдлээ хэтрүүлэх буюу урвуулан ашиглаж, байгууллагадаа хохирол учруулсан бол өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөрөө бүрэн хариуцна.

Ес. Бусад

9.1. Энэхүү дүрмэнд Нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

9.2. Энэхүү дүрмэнд оруулсан нэмэлт өөрчлөлтийг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт мэдэгдэж бүртгүүлнэ.